



# Бичил судалгаа хийх нь

Рэймонд Жервейс

2022




---

## Агуулга

- ❖ Судалгааны хяналт-шинэлгээ, үнэлгээнд гүйцэтгэх үүрэг.
- ❖ Судалгаа үе шатуудыг дэлгэрэнгүй авч үзнэ.



# Өгөгдөл цуглуулах аргууд



## АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ын тодорхойлолт

Цөөн хэдэн тайлбар толь бичигт энэхүү мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны тодорхойлолтыг дурьдсан байдаг. USAID- АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагын тодорхойлсоноор: "Ярилцлага, асуулгын тусламжтайгаар тодорхой хүн амаас мэдээлэл цуглуулах" гэжээ.

Үндсэн шинж чанарууд нь:

- Тоон мэдээллийг цуглуулахад үр ашигтай байдаг;
- Бусад аргуудаас илүү албан ёсны бөгөөд, ихэвчлэн нарийн төвөгтэй хэрэгжилтийн стратегийг шаарддаг. Тухайлбал, энгийн/санамсаргүй, нээлттэй/хаалттай асуултууд;
- Төлөвлөлт хийхдээ цаг хугацаа, зардал, нарийн төвөгтэй байдал гэсэн гурван үндсэн хувьсагчийг хослуулах хэрэгтэй болдог.

## Судалгаа ба хяналт-шинжилгээ

- Санал асуулга нь мэдээлэл цуглуулах хэд хэдэн арга хэрэгслийн зөвхөн нэг нь боловч хяналт-шинжилгээний системийн алдаа, дутагдлыг дараах байдлаар нөхдөг:
  - Хэрэгжилтийн чухал мөчид найдвартай зураг зурах;
  - Зорилтот (эсвэл зорилтот бус) бүлгийн томоохон түүврийн нэмэлт өгөгдлийг нэгтгэх;
  - Тоон болон чанарын мэдээллийг хамтад нь цуглуулах илүү үр ашигтай арга;
  - Эцэст нь суурь судалгаа, дунд шатны үнэлгээ, сэтгэл ханамжийн үнэлгээ зэргийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдийг мэдээллээр хангаж өгдөг.

---

## Бичил судалгаа хийх 7-н алхам

- 1. Судалгааны зорилгоо тодорхойлно
- 2. Баримт бичигтэй танилцах
- 3. Судалгааны асуумж боловсруулах
- 4. Асуулгын хуудсыг зохиох
- 5. Түүврийн төрлийг сонгох
- 6. Холбогдох аргыг сонгох
- 7. Өгөгдөлд дүн шинжилгээ хийх

---

## Алхам 1 & 2

### 1. Судалгааны **зорилгоо тодорхойлох**

Судалгааны зорилгыг нарийн тодорхойлох нь анхаарлаа судалгаандаа төвлөрүүлэхэд тусалдаг бөгөөд ингэснээр зөвхөн хамааралтай, амин чухал асуултуудыг хамардаг. Урьдчилсан төлөвлөлтийн үе шат дахь оролцооны арга барил нь гол оролцогч талуудыг нэгтгэх бөгөөд энэ нь "**мэдэхэд илүүдэхгүй**" сэдвүүдийг орох эрсдлийг бууруулна.

### 2. Баримт бичигтэй танилцах

Төсөл, хөтөлбөрийн тайлан, баримт бичиг, хэвлэгдсэн болон хэвлэгдээгүй судалгаа, төрийн болон хувийн байгууллагуудаар дамжуулан авах боломжтой статистик зэрэг одоо бэлэн байгаа мэдээллийг нягтлан, шинжлэн үзэх. Мөн ижил төстэй болон холбогдох сэдвүүдээр өмнө нь хийгдсэн судалгаануудыг эргэн харахыг хичээх хэрэгтэй.



---

## Алхам 3 & 4

### 3. Судалгааны асуумжаа бэлтгэх

Энэ бол амар ажил биш. Асуултын үг хэллэг, урт, нээлттэй эсвэл хаалттай шинж чанар гэх мэт бүгд хариултад ихээхэн нөлөөлөх боломжтой тул үүнийг сайтар бодож үзэх шаардлагатай. Давтагдах хугацаа нь мөн чухал юм.

### 4. Санал асуулгын хуудсыг зохиох

Дараагийн алхам бол судалгаанд оролцогчдод хялбархан хариулж болохуйц, сайтар нягталсан, богино асуулга боловсруулах явдал юм. Ярилцлагыг хөнгөвчлөхийн тулд бүх асуултыг логик дарааллаар байрлуулах ёстой. Ярилцлага явуулах практик удирдамжийг боловсруулах шаардлагатай.

## Алхам 5 to 7

### 5. Түүврийн төрлийг сонгох

Илүү оновчлолтой магадлалт түүвэрээс эхлээд олон төрлийн сонголт байдаг боловч заримдаа цорын ганц албан бус түүврийн сонгох ч тохиолдол байдаг. Дан эсвэл холимог аль ч тохиолдолд энэ талбар нь сонголтыг шаарддаг.

### 6 Харилцааны төрлийг сонгох

Тухайн нөхцөл байдал нь судалгааг интернет, ярилцлага (биечлэн эсвэл цахим хэлбэрээр), утсаар хийх, эсвэл анкетаар (цахим, шуудангаар эсвэл биечлэн гэх мэт) тараах нь хамгийн үр дүнтэй байх эсэхийг тодорхойлдог.

### 7. Өгөгдөлд дүн шинжилгээ хийх

Заримдаа судалгааны хамгийн сул алхам бол хүний нөөцийг бусад ажилд байн байн илгээдэг. Эрсдэлийг бууруулахын тулд төлөвлөлтийн үе шатанд тодорхой ажилтнуудад үүрэг хариуцлага хүлээлгэж, дүн шинжилгээ хийх төлөвлөгөө гаргахыг зөвлөж байна.



In partnership with  
**Canada**



Mongolia:  
Enhancing Resource  
Management through  
Institutional Transformation

**Address:** Floor 3, National Times News Tower Khudaldaanii gudamj, Khoroo 1  
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

**Phone:** 7610-5000